**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 10 өдөр    Дугаар А/477    Булган сум

Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн $15^{1}$ дүгээр зүйлийн $15^{1}.3$, $15^{1}.4$ дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.Үүнд:

Ажлын хэсгийн дарга: О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд: Г.Давааням (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Б.Одхүү (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Д.Мөнхбаасан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний албаны дарга)

Нарийн бичгийн дарга: Ч.Оюун- Эрдэнэчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний салбарын бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн)

2.Баримт бичгийн бүрдэл шалгах болон магадлан шалгах ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлд заасан хугацаанд шийдвэрлэж, аймгийн Засаг даргад санал хүргүүлж, ажиллахыг Ажлын хэсэг (О.Ундрах)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА    Д.ПҮРЭВ-ОЧИР

Sugar Ажил 2024 өдөр бүр Doc/2024/3захирамж

6324011154